МЭДЭЭ · 2022 оны 3-р сарын 10

ЦАГДАН ХОРИХ, БАРИВЧЛАХ, СААТУУЛАХ АЖИЛЛАГААНД АНХААРАХ АСУУДЛААР ЯРИЛЦЛАА



Нийслэлийн прокурорын газраас Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Цагдан хорих 461 дүгээр хаалттай анги, баривчлах төв байр, саатуулах байр, хорих ангиудын удирдлага, албан хаагч нартай хамтарсан уулзалт, зөвлөгөөнийг зохион байгуулжээ.

Зөвлөгөөнөөр цагдан хорих, баривчлах, саатуулах, хорих ял эдлүүлэх ажиллагааны явцад гарч байгаа нийтлэг зөрчил, дутагдал, прокурорын шаардлагын мөрөөр авсан арга хэмжээ, түүний биелэлтийн талаар болон хорих ангийн эрх бүхий албан тушаалтан зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулахад анхаарах асуудлын талаар ярилцаж, санал солилцсон байна.

Эх сурвалж: https://prosecutor.mn/post/2382